

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын
09-ний өдрийн 206 дугаар тогтоолын
5 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 20

Гучин-Ус сум

Шийд- вэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, төрөл, огноо, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ					
2023 он					
1	1.	2021 оны 12 сарын 17 өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 8.2.Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:	Сумын цахим веб хуудас, Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудас, байгууллагууд мэдээллийн самбарт тухай бүр байршуулан мэдээллийг шинэчлүүлэн иргэдэд цаг үеийн мэдээ, мэдээллийг хурдан шуурхай авах боломж, нөхцлийг бүрдүүлсэн.	90	
	2.	8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Байгууллага бүр эрхэм зорилго, зорилтыг мэдээллийн самбарт ил тод байршуулж, иргэд, ажилтан, албан хаагчид мэдээлэлтэй танилцах бүрэн боломжийг олгосон.		
	3.	8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Ажилтан, албан хаагчидтай харилцах утасны дугаар, шуудангийн хаягийг ил тод мэдээллэсэн.		
	4.	8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын	2022 оны төсөвт хийсэн санхүүгийн аудитын дүгнэлтийг төсөв санхүүгийн мэдээллийн самбарт байршуулж, дотоод хяналтын багийн самбарт жилийн ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж,		

		тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	түүний дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, улирлын тайлан зэрэг мэдээллүүдийг тухай бүр шинэчилсэн.		
	5.	8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Ил тод байдлын нээлттэй үнэлгээ хийж, цахим холбоосыг нэгтгэн тайлагнасан.		
	6.	8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг самбарт байршуулсан.		
	7.	8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, эзэнжүүлэн, хэрэгжилтийг авсан.		
	8.	8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Ажилтан, албан хаагч бүрт хувийн хэрэг бүрдүүлэн хөтөлдөг.		
	9.	8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Сумын хэмжээнд нийт 706 өргөдөл, гомдлыг тухай бүр хугацаанд нь бүртгэн шийдвэрлэж, өргөдөл хүсэлтийн ихэнх хувийг нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, газрын харилцаанд ирсэн өргөдөл хүсэлт санал эзэлж байна. Мөн Нийгмийн халамжид ирсэн хүсэлтүүд цахимаар ирсэн Засаг даргын Тамгын газар нь arms-organization програмд бүртгэл хөтлөн цахимжуулж, ERP системд ажилтан, албан хаагчдын мэдээллийг оруулан, ирсэн, явсан бичиг, өргөдөл гомдлын бүртгэл хийж цахимжуулсан.		
	10.	8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Хөдөө аж ахуйн тариалалт, жижиг дунд үйлдвэрлэл, боловсролын салбарын мэдээллийн системд байгаа багш, ажилтан, суралцагчийн тоон мэдээллийг сумын статистикийн ажилтанд, хүнсний болон бусад мэдээ судалгааг хариуцсан мэргэжилтнүүдэд хүргэсэн.		
	11.	8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг хүүхдийн тайлант өдөрлөг, эцэг эхийн хурал, эцэг эхийн нэрэмжит тэмцээн зэрэг олон нийтийн дунд зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөрийг байгууллагын мэдээллийн самбар, бүлгүүдийн групп чат зэрэгт тогтмол мэдээллэдэг .		
	12.	8.3.Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга	Байгууллага бүр мэдээллийн самбарт хүний нөөцийн мэдээллийг ил тод байрлуулж, сул орон		

		ил тод, нээлттэй байлгана:	тоог тухай бүрт зарлан, нөхсөн.		
13.	8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Ажлын байрны сул орон тоог төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл болон олон нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтын дагуу шалгаруулж, 25 иргэнийг ажилд авсан.			
14.	8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Байгууллага бүр хөдөлмөрийн дотоод журамд сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулах талаар тусгасан бөгөөд сонгон шалгаруулалтын журмыг боловсруулан мөрдөж, дотоод журам, сонгон шалгаруулалтын журмыг мэдээллийн самбарт байрлуулсан.			
15.	8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Байгууллага бүр төрийн албан хаагчын ёс зүйн тухай хуулийн дагуу ёс зүйн дүрэм боловсруулж, ажилтан, албан хаагчдад танилцуулан сургалт зохион байгуулж, мэдээллийн самбар, байгууллагын фэйсбүүк хуудаст байршуулсан.			
16.	8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн стратегийг мөрдөн, веб хуудаст нийтэлж, хэрэгжүүлсэн.			
17.	8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Хүний нөөцийн системд байгууллагын ажилтнуудын мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.			
18.	8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Төсвийн шинэчлэлийн хүрээнд Байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд бүх багш 100 хувь хамрагдсан. Ажилтнуудын үр дүнгийн үнэлгээг засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу дотоод хяналтын нэгж үнэлүүлсэн. Засаг даргын Тамгын газар нь Үнэлгээний баг байгуулж, ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, мэдлэг, ур чадварыг үнэлсний дагуу үр дүнгийн урамшуулалыг 18 ажилтан, албан хаагчид нийт 14,977,800 төгрөг олгосон.			
19.	8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсвийн талаарх мэдээллийг нягтлан бодогч нийт ажилтнуудад танилцуулж, худалдан авах ажиллагааны tender.gov.mn болон мэдээллийн самбар фэйсбүүк хуудаст байршуулсан.			
20.	8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн	Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан.			

		жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;			
21.	8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан.			
22.	8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын мэдээллийг шилэн данс болон сумын веб хуудаст нийтэлсэн.			
23.	8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2021, 2022, 2023 оны хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамжийг хэмжээг тогтоосон тогтоолыг тухай бүр цахимд байршуулсан.			
24.	8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг сар бүр сумын веб хуудас, шилэн дансанд байршуулсан.			
25.	8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг сумын веб хуудас, шилэн дансанд байршуулсан.			
26.	8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагыг сумын веб хуудас, шилэн дансанд байршуулсан.			
27.	8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сумын веб хуудас, шилэн дансанд байршуулсан.			
28.	8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэлийг сумын веб хуудас, шилэн дансанд байршуулсан.			
29.	8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер	Тендер шалгаруулах журам, урилга, шалгарсан, шалгараагүй тендерийн мэдээлэл, шалгуур үзүүлэлтийг сумын веб хуудаст нийтэлсэн.			

		шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;			
30.	8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Сумын веб хуудаст нийтэлсэн.			
31.	8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Сумын веб хуудаст нийтэлсэн			
32.	8.4.13.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт;	Сумын веб хуудаст нийтэлсэн			
33.	8.4.15. улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт;	Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг сумын веб хуудаст нийтэлсэн.			
34.	8.4.19.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;	Сумын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сумын веб хуудаст нийтэлсэн.			
35.	8.4.20. төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан;	Сумын төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан веб хуудаст нийтэлсэн.			
36.	8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Монголын хоолойн тэмээг омог болгох судалгааны ажлын мэдээллийг байршуулсан.			
37.	8.4.28.хууль тогтоомжид заасан бусад.	Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын талаарх мэдээллийг сумын веб хуудаст байршуулсан.			
38.	8.5.Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:	Ажилтан, албан хаагчдын хариуцсан ажил үүргийн дагуу үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг фэйсбүүк хуудаст оруулж, хэвшсэн.			
39.	8.5.1.үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг,	Иргэний бүртгэлийн 8 лавлагаа, архивын лавлагаа, газрын талаарх лавлагааны төлбөр,			

		түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	хураамжийн мэдээллийг веб хуудаст байршуулсан.		
	40.	8.5.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Шинээр газар олгосон, сунгасан, хүчингүй болгосон, шилжүүлсэн тухай мэдээллийг сумын веб хуудаст байршуулсан.		
	41.	8.6.1.олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Газрын багц хууль батлагдахтай холбогдуулан хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.		
	42.	8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээллийг сумын веб хуудаст байршуулсан.		
	43.	8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Засаг даргын Тамгын газрын эзэмшиж байгаа газрын мэдээллийн сумын веб хуудаст байршуулсан.		
	44.	8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Хэрэгжээгүй		
2019 он					
2	45.	Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01 8.1.Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XII дугаар ээлжит хуралдаанаар малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн баталж тэмээ 200, адуу 600, үхэр 400, хонь 600, ямаа 800 төгрөг байхаар шинэчлэн тогтоож, хуралдаанаас гарсан тогтоол, нөлөөллийн шинжилгээний дүн, хэлэлцүүлгийн тайлан, санал асуулгын хуудас зэрэг холбогдох	100	

			материалуудыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, захиргааны хэм хэмжээ актын нэгдсэн санд бүртгүүлсэн.		
2016 он					
3	46.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (Шинэчилсэн найруулга) 2016-12-22 Дугаар 2017.02.01 18.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 заалттайгаар баталж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, иргэдэд цахим болон гарын авлага хэлбэрээр эрх зүйн мэдлэг, мэдээлэл өгсөн.	100	
	47.	18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн ГХУСАЗСЗ-өөс 300,000 төгрөгний санхүүжилт олгогдож, төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримтат тайланг холбогдох газарт хүргүүлсэн.		
	48.	19.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөний дагуу “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр 250 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, Ерөнхий боловсролын сургуулийн 5-12-р ангийн сурагчдын дунд “Гэр бүлийн хүчирхийлэл миний нүдээр” гар зургийн уралдаан зохион байгуулж, ирсэн бүтээлүүдийг нөлөөлөх байдлаар олон нийтэд танилцуулсан. АА-гийн нийгэмлэгээс 6 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын баг урьж, “Эрүүл харилцаа, Зөв амьдрал” сэдвээр нээлттэй сургалт явуулж, 42 хүн хамрагдсан. Архины давхар хамааралтай 2 хүнтэй тусгай уулзалт хийж, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг Засаг даргын Тамгын газрын фейсбүүк хуудсаар мэдээллэж 1,676 хандалт		

			авсан.		
	49.	19.1.2.Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	Хүүхэд хамгааллын “Хамтарсан баг” нь Засаг даргаар ахлуулсан 11 гишүүдээс бүрдсэн. 9 заалт бүхий төлөвлөгөө хэлэлцэн, боловсруулж, 5 удаа багаар хуралдаж, 2 кейс, 3 удаагийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, гишүүдийг чадавхжуулах сургалтад 2 хамруулж, үүрэг оролцоог нэмэгдүүлэх дотоод сургалтыг 1 удаа хийсэн.		
Хэсгийн дундаж 96,6					
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
2023 он					
4	50.	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023_07_19 Дугаар 2023_279 1.Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг 1 дүгээр хавсралт, Аймгийн төвийн хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэх махны хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.	Сумын Засаг даргын А/120 дугаар захирамжаар батлагдсан Ажлын хэсэг өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах төлөвлөгөөг 7 бүлэг 43 заалттай гаргаж, биелэлтийг ханган зудын эрсдлээс урьдчилан сэргийлж, 4,700 ногоон тэжээл, 1,400 боодол өвс, 20тн хивэгний нөөцийг бэлтгэсэн. Малчид мал сүргээ эдийн засгийн эргэлтэнд оруулан аймгийн махны үйлдвэрүүдтэй хамтран хонь 2,556, адуу 519, үхэр 102, ямаа 1,742, тэмээ 140, хонины мах 42,208кг, адууны мах 8,150кг, ямааны мах 10,155кг, тэмээний мах 19,170кг, үхрийн мах 2,800кг, толгой шийр 500ш, цувдай 86ш гарал үүслийн гэрчилгээ авч, худалдан борлуулалт хийснээр малчид эр сувай болон хэрэгцээний сүргийг зах зээлд борлуулж, бэлчээрийн даац хэтрэлтээс урьдчилан сэргийлсэн.	100	

5	51.	Журам шинэчлэн батлах тухай 2023-08-23 Дугаар 2023_301 1."Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.	Засаг даргын Тамгын газар нь Үнэлгээний баг байгуулж, ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ажлын гүйцэтгэл, мэдлэг, ур чадварыг үнэлсний дагуу үр дүнгийн урамшуулалыг 18 ажилтан, албан хаагчид нийт 14,977,800 төгрөг олгосон.	100	
2022 он					
6	52.	Журам шинэчлэн батлах тухай 2022-01-05 Дугаар 2022_02 1."Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. 2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	"Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тайлан мэдээг гаргаж мэдээллийн санд тогтоосон хугацаанд бүрэн оруулсан. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 50хувь буюу 157сая 350.0 төгрөг байгаль хамгаалах санд төвлөрүүлж ажлын төлөвлөгөөг гарган ИТХурлаар батлуулснаар 141.074,584 зарцуулалт хийж, 16.275,416 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгаль орчныг хамгаалах, ан амьтны амьдрах орчныг сайжруулах, бэлчээр хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг ажлууд хийснээр иргэдийн байгаль орчны талаарх эрх зүйн мэдээлэл дээшилсэн.	70	
7	53.	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-01-05 Дугаар 2022_7 5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:	Сумын Засаг даргын А/50 дугаар захирамжаар "Хэлний бодлогын салбар зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, Үндэсний бичиг үсгийн баярын өдрөөр ЕБС-ын 6-9 дүгээр ангийн сурагчид, насанд хүрэгчдийн дунд "хичээнгүй,алдаагүй бичигтэн", "хурдан зөв уншлага" уралдаануудыг явуулж хэвшсэн.	100	
		5.2.төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;	Сумын веб хуудас, төрийн байгууллагууд фэйсбүүк хуудсаар иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэхдээ кириллээр бичиж хэвшсэн.		

	54.	5.4.төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх	Төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн түвшинг тогтоож, сургалт зохион байгуулан 29 төрийн албан хаагч хамрагдан, 25 нь түвшингээ ахиулсан. Улирал бүр монгол бичгийн Хүмүн бичиг сонинг захиалж, уншлагын цагтай болсон.		
	55.	5.5.төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Байгууллага гадна хаяг, албан өрөөний хаягийг монгол, крилл бичгээр хийж, хаягжуулсан.		
8	56.	Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар 2022_118 5.Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 3.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Төл сонгино, сармис, байцаа, шар лууван, шар манжин, хүрэн манжин, сармис, өргөст хэмх, лооль, навчит салатны үрийг 22 тариалан эрхлэгчид 80 хувийн хөнгөлөлттэй үнээр, 1,2тн төмсийг 800 төгрөгөөр өгч тариалан эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, сумын Цэцэрлэгт Засаг даргын Тамгын газраас “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд 3х6м хэмжээтэй хүлэмж өгч, туршилтын талбай, хүлэмжээс чацаргана 45кг, төмс 100кг, манжин 20кг, сонгино 15кг, лууван 20кг, улаан лооль 5кг-ыг тус тус хураан авч, сумын хөрсөнд ургасан эко бүтээгдэхүүнийг хүүхдүүдийн хоол хүнсэнд хэрэглэх боломжийг бүрдүүлэн, аймгийн Хөдөө аж ахуйн газраас 4х8 хэмжээтэй 2 хүлэмж өгсөнийг олон жил тариалан эрхэлж буй 2 тариаланчдад хүлээлгэн өгч, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг дэмжин, өрхийн орлогийг нэмэгдүүлсэн.	100	
9	57.	Журам батлах тухай 2022-03-02 Дугаар 2022_92 2.“Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. 3.Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт бүхий мал, амьтныг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг,	Тэмээн сүргийн биологийн онцлог ашиг шимийн судалгааны арга зүйн дагуу сумын Засаг даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсэг тэмээн сүрэгт хавар, намрын ангилалтыг зохион байгуулж, хаврын ангилалтаар эр, эм ноосны гарц, эм ноосонд ноолуурын эзлэх хувь, зогдорын урт, ингэний сүүний гарц, ботгоны өсөлтийн судалгаа, амьдын жинг тогтоох, намрын ангилалтаар атан тэмээний нядлагын гарц тогтоох, бэлчээрийн ургамлын судалгаа хийсэн.	100	

		нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Эр, эм ноосны дээж, ургамлын дээжийг шинжлүүлж, судлуулахаар Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лабораторт явуулж, 3 атан тэмээний сойлтын өмнөх жин, сойлтын дараах жингүүдийг үзэж нядлагын жинг тогтоон, 20 торомтой ингэ, 20 ботготой ингэний сүүний дээжийг, өсвөрийн эр, эм тус бүр 5 тэмээ, нас бие гүйцсэн эр, эм тус бүр 5 тэмээнээс цусны дээж авч Мал аж ахуйн эрдэм шинжилгээний төв лабораторт хүргүүлэн Монголын хоолойн тэмээг омог болгох ажлыг эрчимжүүлсэн.		
10	58.	Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-02-23 Дугаар 2022_81 3.“Хоршооны хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т тус тус үүрэг болгосугай.	Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийг дэмжих зорилгоор Хоршоо хөгжүүлэх сангаас 1 аж ахуй нэгж, 5 иргэнд 77,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг сүү, цагаан идээ боловсруулах, гутлын үйлдвэрлэлээ өргөтгөх, эсгий урлал болон малын хялгас, ноос хөөврөөр гэрийн оосор бүслүүр хийх, гар урлал, модон эдлэл, газар тариалан эрхлэх, эрүүл зохистой хоол үйлдвэрлэлийн чиглэлээр зээлийг олгож, гар урлалаар үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж болон иргэдээ дэмжин ажиллаж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.	100	
11	59.	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2022-03-16 Дугаар 2022_120 2.Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөр төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Цэргийн дүйцүүлэх албыг 6 хүн хааж, мөнгөн төлбөр төлүүлэх иргэн байхгүй.	100	

12	60.	Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай 2022-07-05 Дугаар 2022_267 1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэж байгаа геодезийн хэмжилт, зураглалын ажилд олон улсын геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоо, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, газрын зураглалд дэлхийн хөндлөн меркаторын "UTM" тусгагийг тус тус хэрэглэж байхаар тогтсугай.	Олон улсын геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоо, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, газрын зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM тусгагийг ашиглан 5 айлын байшин, 8 хашааны газар, 2 төсөвт байгууллагын барилга, инженерийн шугам сүлжээний газрын хэмжилт зураглалыг хийсэн.	100	
2021 он					
13	61.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-12-14 Дугаар 2021_397 1.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. 1.1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн өмнөх онд хийсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж санхүүжүүлэх;	Өмнөх онд дутуу хэрэгжсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын дутуу санхүүжилт байхгүй. Харин Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 214.0сая төгрөгийн сумын төвийн дулааны шугамын өргөтгөлийн тендрийн үлдэгдэл санхүүжилт 50.0 сая төгрөгийн дутууг аймгийн Засаг даргын төсвийн багцын дүнд оруулан, санхүүжилтээ бүрэн авсан.	100	
	62.	1.2.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөллөөс үүдэн үлдэгдэлээр үлдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдэл байхгүй.		

		олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;			
14	63.	Жагсаалт батлах тухай 2021-12-01 Дугаар 2021_359 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 6 (Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлдэгчийг сонгон шалгаруулах, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэх, инженерийн хийцтэй 2 гүний худаг гаргах, сумын төвийн дулааны шугамын дагуу дулаалгатай цэвэр усны шугам хоолой тавих) тендерийг (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, 6 тендерийн үр дүнг тухай бүр цахим системд байршуулсан.	100	
15	64.	Аж ахуйн нэгжийн тооллого явуулах тухай 2021-10-13 Дугаар 2021_315 3.Аж ахуйн нэгжийн улсын тооллогод өөрийн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг бүрэн хамруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж, тооллогын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, тооллогын ажилд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг явуулж, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн нийт 2,628,206,500.41 төгрөгний хөрөнгийг тооллогот хамруулсан. Үүнээс дахин ашиглах боломжгүй 61,093,800 төгрөгийн 12 ширхэг эд хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт, 15,252,035 төгрөгийн 25 ширхэг эд хөрөнгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар оруулан хэлэлцүүлж, актлуулсан. Ерөнхий боловсролын сургууль нь ажлын хэсэг томилж, эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, програмд бүртгэсэн.	100	
	65.	Үдийн хоолны норматив тогтоох тухай 2021-08-11	Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн 168 хүүхдэд 2 ээлжээр 1 хүүхдийн 1,500		

16		Дугаар 2021_237 4.Энэ тогтоолын 1, 3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд 2021 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг 2021 онд батлагдсан төсвийн багцдаа зохицуулалт хийж, 2022 оноос улсын болон орон нутгийн төсвийн төсөлд зохих журмын дагуу тусган хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	төгрөгийн батлагдсан төсөвт багтаан өр авлагагүй ажиллаж байгаа боловч 1,500 төгрөгөнд үдийн хоол хийж өгөхөд үнийн өсөлттэй холбоотой хүндрэл гарч байна.	100	
17	66.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-03-24 Дугаар 2021_70 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онуудад сумын эрүүл мэндийн төвийн 1,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй больницын барилга баригдаж байна. Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй Эрүүл мэндийн төвийн барилгын ажил болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй инженерийн хийцтэй 2 гүний худаг гаргах, сумын төвийн дулааны шугамын дагуу цэвэр усны шугамын ажил хийх, 4 багт 10 инженерийн хийцтэй, гар худгийг 13.0сая төгрөгөөр сэргээн засварлах, “Монголын хоолой”-н хүрэн тэмээг омог болгон батлуулах судалгааны ажилд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдээр хяналт шалгалтыг тухай бүр хийлгэсэн. Гэрээний үүргээ зөрчсөн аж ахуй нэгж гараагүй.	100	
	67.	1.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбогдуулан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрий 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд спорт заалны барилга бариулах төсвийн төслийг хуулийн хугацаанд буюу 5 дугаар сарын 01-ний дотор программд шивж оруулсан.		

18	68.	“Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл” батлах тухай 2021-03-10 Дугаар 2021_58 3.Энэ төсөлд хамрагдсан залуучуудыг ажлын байраар хангах талаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүтээн байгуулалтын болон бусад холбогдох төсөл, арга хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл болгосугай.		100	Энэ онд аймгийн хэмжээнд залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл хэрэгжээгүй.
19	69.	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-02-17 Дугаар 2021_43 1.1. үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах	Батлагдсан төсөвтөө багтаан жилийн эцсээр өглөг, авлагагүй гарахаар төсвийг тооцоолсон.	100	
	70.	1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх	Энэ онд шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, орон тоо нэмэгдээгүй.		
	71.	1.3.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр	Ерөнхий боловсролын сургуульд 2 багш, 1 эмчийн орон тоонд ажиллах хүч байхгүйн улмаас цалингийн зардал хэмнэж байгаа боловч Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор хувьсах зардал		

		ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;	хүүдийн тооноос хамаарч санхүүждэг болсон нь цалин сан жилийн дүнгээр 2,852,393 төгрөг хэмнэж байна.		
	72.	1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;	Төсөвт байгууллагууд автомашин, албан конторын тавилга, ажлын дүрэмт хувцас, фитнесийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгээгүй.		
	73.	1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;	Үндэсний их баяр наадмаас бусад тэмдэглэлт баяр ёслолын арга хэмжээг төсвийн хөрөнгөөр зохион байгуулаагүй.		
		1.7. хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх;	Нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны зардлыг санхүүжүүлээгүй.		
	74.	1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;	Эрүүл мэндийн төв цэвэр бохирын зардалыг 20, түлш халаалтын зардлыг 26, цахилгааны зардалыг 50, Засаг даргын Тамгын газар түлш, халаалтын зардлыг 16.8, цэвэр, бохир усны зардлыг 100 хувиар тус тус хэмнэн ажилласан.		

	75.	1.9. бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах.	Төсөвт байгууллагууд ERP, gmail, албаны мэйлийг ашиглан цахимаар мэдээлэл солилцож байгаа хэдий ч бичиг хэргийн зардлын үнэ нэмэгдсэнтэй холбоотой хэмнэлт гараагүй.		
20	76.	Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар 2021_18 2.Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.	Дотуур байрын сурагчдын хоо, бага ангийн сурагчдын үдийн хоолны цэсийг улирал бүр шинэчлэн баталж, хоол үйлдвэрлэлийг 4 тогооч хариуцан хийдэг.	100	
21	77.	Жагсаалт батлах тухай 2021-01-15 Дугаар 2021_15 3.“Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.	Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн багш нарын гар утасны дата багцыг бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааны ерөнхий гэрээний хүрээнд худалдан авалтыг хийсэн.	100	
2020 он					
22	78.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020-05-06 Дугаар 2020_163 3.Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж,	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, 6 төсөвт байгууллагын 103 төрийн албан хаагчид 1,742.1сая төгрөгийн цалинг цахимаар баталгаажуулан, и-мэйл хаягт цалин бодолтын мэдээллийг тухай бүр хүргэснээр ажилтан, албан хаагчид өөрийн цалинг хянах боломж бүрдсэн.	100	

		мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.			
23	79.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-04-29 Дугаар 2020_151 3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай.	Төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоогүй. Өндөр настны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж урамшуулал буюу 36 сарын тэтгэмж олгосон.	100	
24	80.	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144 1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай.	Эрүүл мэндийн төвийн шинээр 11 сард ашиглалтанд орсон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд стандарт шаардлагад нийцсэн 2 давхар, 15 ортой барилга нь дулааны эрчим хүчийг хэмжих тоолуур байрлуулсан.	30	Бусад төсөвт байгууллагууд дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжих тоолуур тавих төсөв хүрэлцэхгүйн улмаас тоолууржуулаагүй.
25	81.	Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2020-04-15 Дугаар 2020_138 2.Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гадаргын болон газрын доорх усыг ашиглах боломжтой байршилд шинээр тариалангийн газар	Газар тариалан шинээр эрхэлж буй иргэдийг “Ар агуйн хишиг” хоршоог түшиглэн тариалан эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, төмс 5.7га-д 58тн, хүнсний ногоо 4.97га-д 46тн, ногоон тэжээл 15га-д 48тн-ийг хураан авч, сумын иргэдийг хүнсний ногоогоор ханган, Атаршсан 10га газрыг эргэлтэд оруулж, гүний худаг барин, “Малчдын нөхөрлөл бүлэг”-тэй хамтран 30тн малын тэжээл, 4 үрийн найрлагат 1тн малын тэжээлийн үрийг өвөлжөө,	100	

		эзэмшүүлэх, ашиглаж байгаа тариалангийн талбай хоорондын зайд тэлэлт хийж өргөтгөх, тариалан эрхлэх газарт иргэдэд зөвхөн хүнсний ногоо тарих зориулалтаар талбай олгох, цаашид зориулалтыг өөрчлөхгүйгээр тариалах талбайг нэмэгдүүлэх боломжийг судалж, хууль, журмын хүрээнд зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай..	хаваржаандаа тариалах хүсэлтэй 10 айл өрхөд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгон, тариалж, нийт 5тн ургац хураан авч, “Есөн ган хүлэг” хоршоотой хамтын гэрээ хийн 1га талбайгаас 100-130 боодол ногоон тэжээл бэлгэж, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлсэн.		
26	82.	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_18 4.Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарын 20-оос доошгүй хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого баримтлан аймгийн махны үйлдвэрүүдтэй хамтран хонь 2,556, адуу 519, үхэр 102, ямаа 1,742, тэмээ 140, хонины мах 42,208кг, адууны мах 8,150кг, ямааны мах 10,155кг, тэмээний мах 19,170кг, үхрийн мах 2,800кг, толгой шийр 500ш, цувдай 86ш гарал үүслийн гэрчилгээ авч, худалдан борлуулалт хийсэн.	100	
2018 он					
27	83.	Журам батлах тухай 2018-03-04 Дугаар 2018_71 1."Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.	Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам, Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журмуудын хүрээнд тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийн бүрдэл хангасан 42 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, өндөр насны тэтгэвэр тогтоон, тэтгэврийн нас хүрсэн ч ажилласан жил хүрээгүй, ямар нэгэн бичиг баримтын зөрчилтэй малчид, даатгуулагчдад холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч, иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийн талаарх ойлголтыг нэмэгдүүлсэн.	100	

28	84.	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	Давхардал, хийдэл илрээгүй.	100	
		1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Төрийн жинхэнэ албан хаагчын 4 сул орон тоог Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж, нөхөн томилж, түр орлон гүйцэтгүүлсэн.		
		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Ажлын цагаар болон томилолтоор явах үед архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, хэрэглэсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заалт оруулж батлан, зөрчил илрээгүй.		
		1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Ажилтнуудын цаг ашиглалт, ажлын цагийг камерын хяналтаар хянаж, ажиллаж байна.		

		1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, ёс бус үг хэллэг, үйлдэл гаргахгүй байх, хамт олны дунд эвсэг уур амьсгал бүрдүүлэхээр баталж, ажилтан, албан хаагчдаас ажлын байрны дарамт, шахалт үзүүлсэн гомдол, санал ирээгүй.		
2016 он					
29	85.	Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2016-01-04 Дугаар 2016_10 1."Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг 1 дүгээр, "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай	"Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын дагуу газар эзэмшүүлж, гэрчилгээжүүлэх дуудлага худалдааг 2 удаа зарласан.	100	Оролцогч оролцоогүй.
2007 он					
30	86.	Журам шинэчлэн батлах тухай /Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257 2.Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	"Дарги тайж" ургийн баримтат кино хийж, ургийн баяраа тэмдэглэсэн 2 ураг удмыг хамтран ажилласан. Үүний үр дүнд ах, дүү, төрөл садангаа таньж, мэдэн, ургийн хэлхээгээ сайжруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн 62 сурагчдад ургийн бичиг хөтлөх тухай мэдээлэл өгсөн.	100	
Хэсгийн дундаж 92,2 хувь					
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ					
2021 он					

31	87.	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах	Ажил идэвхтэй хайж буй 5 иргэнийг түр ажлын байраар ханган нийтийн эзэмшлийн талбайн модны хашаа солих 1,200 модны хамгаалалтыг сайжруулан 4,389м2 талбайд хамгаалалтын тор татаж, бургас 100, чацаргана 80-ыг, албан байгууллагууд хайлаас 952, бургас 690, айл өрхүүд 448, нийт 2,320 мод бутыг тариалсан. Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хариуцсан 2 ажилтныг гэрээгээр ажиллуулснаар модны ургалт сайжирч, ногоон байгууламжийн хэмжээ 10 хувиар нэмэгдэж модны ургалт 85 хувьд хүрсэн.	100	
		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Сумын хэмжээнд 2 цэцэрлэгт хүрээлэн байгуулж жил бүр нөхөн тарилт хийн усалгаа арчилгааг тогтмолжуулаад байна. Эдгээр цэцэрлэгт хүрээлэнгүүдэд нийт 1500 гаруй мод бут ургаж сумын өнгө үзэмжийг нэмснээр иргэдийн мод тарих идэвх санаачлага жилээс жилд нэмэгдэж байна.		
		2.Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Мод тарих өдрүүд, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр Аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэнүүдтэй хамтарсан сургалт, АХА тэмцээнийг зохион байгуулж 87 төрийн албан хаагч, 48 сурагч, цэцэрлэгийн 23 хүүхэд нийт 158 хүн оролцсноор байгаль хамгаалалын талаар иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн.		
2019 он					
32	88.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 1.16. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих 2. Амьд явах, амьдрахын сайн сайхныг олон нийтэд сурталчлан таниулах, дээрх агуулага	Ерөнхий боловсролын сургуулиас 500 метрийн дотор орших 2 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийн, түргэн хоолоор үйлчилдэг 1 хоолны газарт мэдээлэл өгч, зөвлөн тусласан.	70	

		бүхий бүтээл, нэвтрүүлэг, мэдээлэлд ард иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг идэвхийлэн оролцохыг уриалсугай.			
Хэсгийн дундаж 85 хувь					
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
2023 он					
33	89.	2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр 10 дугаар тэмдэглэл Дугаар 2023_10 Мал амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох Мал эмнэлгийн цоц арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай	Мал эмнэлгийн Ерөнхий газрын дарга, аймгийн мал эмнэлгийн газрын даргын тушаалуудаар баталсан хуваарийн дагуу вакциныг татан авч Сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/52 дугаар захирамж 10 сарын 23-ны өдрийн А/125 дүгээр захирамжуудын дагуу сумын нийт үхэр сүрэгт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2 удаа зохион байгуулж нийт 5,746 үхрийг вакцинд хамруулан малын гоц халдварт өвчин гараагүй тайван бүсээ хадгалж чадсан.	100	
2022 он					
34	90.	2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр 9 дүгээр тэмдэглэл 2022-02-09 Дугаар 2022_9 Ү.5.Монгол Улсын төсвийн санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс шинээр эхлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, орон нутагт эрх нь шилжсэн худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Сумын Эрүүл мэндийн төвийн 1,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ортой больницын барилгын ажлыг аймгийн Худалдан авах ажиллагааны газраар 2022 онд тендерийг нь зарлуулан “Дуутын нуруу” ХХК шалгарч 6 сарын хугацаанд барьж гүйцэтгэн хүлээлгэн өгч, ашиглалтад орсон.	100	
35	91.	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 2.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ	“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд Ehalamj.mn цахим системээр 18 иргэн үйлчилгээнд хамрагдахаар хүсэлт ирүүлж, өөрийн эрхээр 374 иргэний өргөдөл хүсэлтийг бүртгэн, зөвлөн туслаж, Egazar цахим системийн ач холбогдолыг	100	

		үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	үйлчлүүлж буй бүх иргэдэд тайлбарлаж өгч 7 иргэнд Egazar апплекейшн татаж өгөн цахим хүсэлт илгээж, Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудсаар 3 удаа Сумын газрын даамлын фэйсбүүк хуудсаар 5 удаа нийтлэн мэдээллэн, daatguulagch.ndaatgal.mn сайтаас Жирэмсэн амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээж шийдвэрлүүлсэн 11 иргэн, Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1 иргэн, тэтгэврээ өөрчлүүлэн тогтоох хүсэлтээ илгээж шийдвэрлүүлсэн 25 иргэн, www.ndaatgal.mn сайтаас сайн дураар шимтгэл төлдөг нийт 180 иргэний гэрээг сунгаж баталгаажуулж, төрийн үйлчилгээний Хурдан киоскоор 11 төлбөр төлүүлэн, И-Монголиа системээр 160 иргэнд нийгмийн даатгалын тодорхойлолт, төрсний гэрчилгээний лавлагаа, иргэний үнэмлэхний лавлагаа, зээлийн мэдээллийн лавлагаа, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагааг олгож, иргэдийн идэвхтэй ашигладаг платформуар Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газар фэйсбүүк хуудас нээн сурталчилснар иргэдийн цагийг хэмнэн, төрийн үйлчилгээг хаанаас ч түргэн шуурхай авах боломжийг нэмэгдүүлсэн.		
36	92.	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дүгээр тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16 3.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төслөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлууд нь зураг төсвөө урьдчилан хийлгэсэн. Зураг төсвийн өглөггүй төсөл, арга хэмжээг баталсан.	100	
	93.	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55			

37		дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55 ХҮ.9.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудлыг ирэх оны төсөв батлагдсан даруйд шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарлаж 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан байхаар тооцож, бэлтгэл хангахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгав;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэх ажлын эрх шилжүүлэх тендерийн ажил байхгүй. Спорт заалтай болох 1,200.0сая төгрөгийн төсөвт өртөгтөөр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалтын саналыг программд шивж оруулсан.	100	
	94.	ХҮ.13.6.“Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад;	Тендер шалгаруулалтын онцгой журам буюу харьцуулалтын аргаар “Баянговь-Ус” ХХК гүн өрмийн 2 худгийг 65.0сая, Сумын төвийн дулааны шугамын дагуу дулаалгатай цэвэр усны шугам хоолой тавих ажил 78.2сая, Багийн төвийн засварын ажил 36.0сая, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн хоолны материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах, эрүүл мэндийн төвийн шатахуун нийлүүлэгчийг сонгох 7 тендерийг 100 хувь цахимаар зохион байгуулж, цахим тендерийн урилга, үр дүнг тухай бүрт нийтэлж, ил тод байдлыг хангасан.		
2020 он					
38	95.	2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2020-04-01 Дугаар 2020_22 ХҮИИ.2.2. Дараах арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1.Худалдан авах ажиллагааны	Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг төсөв батлагдсан даруйд 2022 оны 12 дугаар сард tender.gov.mn сайтад шууд худалдан авах 12 ажил, тендер шалгаруулалтын онцгой журам-харьцуулалтын аргаар 9 тендер бүгд 566,799.0 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө гарч программд шивэн ил тод байдлыг ханган ажиллсан.		

		төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2.Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх;	Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 6 (Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлдэгчийг сонгон шалгаруулах, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийүүлэгчийг сонгон шалгаруулах, эрүүл мэндийн төвд шатахуун нийлүүлэх, инженерийн хийцтэй 2 ширхэг гүний худаг гаргах, сумын төвийн дулааны шугамын дагуу дулаалгатай цэвэр усны шугам хоолой тавих) тендерийг (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, 6 тендерийн үр дүнг гэрээ, ажил хүлээлцсэн актын хамтаар тухай бүр цахим системд байршуулсан. Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээг байгуулсан. Гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуй нэгж байхгүй тул иргэдээс гомдол ирээгүй.	100	
Хэсгийн дундаж 100 хувь					
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР					
	96.	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2 1.2.Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо,	Улирал бүр хамгийн их авсан 10 лавлагааг жагсаан, тайланг холбогдох газарт хүргүүлсэн		

39		мэдээллийн технологийн газарт хүргүүлэх;		100	
	97.	1.3.Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх;	Нэг албан хаагчийг операторын чадавхжуулах сургалтад хамруулан, иргэдэд лавлагаа, мэдээлэл өгсөн		
	98.	1.4.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх;	Төрийн үйлчилгээний И-Монголиа системээр 160 иргэнд нийгмийн даатгалын тодорхойлолт, төрсний гэрчилгээний лавлагаа, иргэний үнэмлэхний лавлагаа, зээлийн мэдээллийн лавлагаа, иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн лавлагааг олгож эхэлснээр иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн.		
	99.	1.5.Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Төрийн үйлчилгээний E-Mongolia системээр лавлагаа өгөхдөө иргэдийн тоон гарын үсгийг 7 удаа ашигласан.	100	
	100.	1.8.Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах;	Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк хуудсаар төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia, Киоск, EGazar зэргийн мэдээллийг 56 удаа нийтэлж, 1,750 хандалт авч, иргэдийн мэдээллийг дээшлүүлсэн.		
	101.	1.9.Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох.	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-ийг нэвтрүүлэн байгууллагын 20 ажилтан, албан хаагчдын бүртгэн бүх албан хаагчдад мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн.		
Хэсгийн дундаж 100 хувь					
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ					
2016 он					

40	102.	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;	Хүн амын дунд БЗДХ ба ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өсвөр насны ба цэргийн насны залуучуудыг танхимаар сургалт зохион байгуулж, 128 хүн хамрагдсан Өвчлөл илрүүлэх зорилгоор шинжилгээнд цэргийн насны 86, өсвөр насны 64 охид хөвгүүд , жирэмсэн эхчүүд 28, гэр бүл болж байгаа 6 хүн эрсдэл бүлгийн 39 хүнийг шинжилгээнд хамруулсан, Дэлхий нийтээр ДОХ тэмцэх өдөр Төрийн албан хаагч 35-аас доош насны залуучуудыг шинжилгээнд хамруулж, сургалт хийж, ДОХ-ын талаарх мэдлэгийг сайжруулсан.	100	Өөр аймаг, хотод оршин сууж байгаа өөрийн харьяалалын хүмүүсийг бүрэн хамруулахад зардал бензин оношлогоо шинжилгээний хэрэглэгдхүүн хэрэгтэй учир санхүүжүүлэхээ р олон улсын байгууллагад төсөл бичиж хүргүүлсэн.
----	------	--	--	-----	--

41	103.	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)	Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг дадлыг дээшлүүлэх сургалтыг байгууллагын дотоодын сургалтаар 2 удаа, танхимын сургалтад 2 эмчийг оролцуулж, сүрьеэтэй өвчтөний хавьтал болох 18 иргэнийг БОЭТ-ийн сүрьеэгийн тасагтай хамтран 2 удаагийн урьдчилан сэргийлэх сургалт үзлэг оношилгоонд хамруулж сүрьеэгээр өвчлөх өндөр эрсдэл бүхий 124 иргэнийг асуумж үзлэг, шаардлагатай 16 иргэнийг рентген шинжилгээ, 3 иргэнийг цэрний шинжилгээнд хамруулахад сорьцны хариу “Сөрөг” гарсан. Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 39 сурагчийг үзлэг, оношилгоонд 2 удаа, цэргийн насны 79 залууг оношилгоо, шинжилгээнд, зорилтод бүлгийн нөхөн үржихүйн насны 16 эмэгтэй, албан байгууллагын 25-49 насны ажилчдыг үзлэг, оношилгоонд хамруулан, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн.	100	
Хэсгийн дундаж 100 хувь					
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ					
2010 он					
42	104.	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09 1.Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх, 3.Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг	Сумын Онцгой комисс, Ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 86 бие бүрэлдэхүүнийг “Стратегийн команд штабын сургууль”-ийн цахим сургалтад хамруулж, төрийн албан хаагчид, аж ахуй нэгж, иргэдэд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэлтэй байх, тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ авах, газар хөдлөлтийн дараа хаана, хэнд хандах талаар мэдээллүүдийг өгч, газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “Онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт цагийн байдалтай ажиллаж, шийдвэр гаргах дадлага сургуулийг хийж, аранзан дахь хүнсээрээ хоол хийх аргыг эзэмшин бие	100	

		давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	хүнсээрээ хоол хийх аргыг эзэмшин бие бүрэлдэхүүнийг чадавхжуулсан		
Хэсгийн дундаж 100 хувь					
Нийт дундаж 96,2 хувь					

100*39=3900 (Үр дүнтэй)

90*1=90 (Тодорхой үр дүнд хүрсэн)

70*2=140 (Эрчимжүүлэх шаардлагатай)

30*1=30 (Үр дүнд хүрээгүй)

Биелэлт 96,7 хувь

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Х.ЭНХТАЙВАН

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Л.МӨНХЖАВХАА